



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№99 /313/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.05.26

Цаг үе, үйл явдал

СЭЛЭНГЭ АЙМГИЙН “ДӨЛ-2022” ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНИЙ ШИЛДГҮҮД ТОДОРЛОО



Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Сэлэнгэ аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын “ДӨЛ-2022” цогцолбор тэмцээнийг сум, бүс, аймаг гэсэн 3 үе шаттай амжилттай зохион байгуулав.

Эхний шатыг 4 дүгээр сарын 22-ны өдрөөс 28-ны өдрүүдэд аймгийн Ерөнхий боловсролын 34 дүгээр сургуулийн 1700 гаруй сурагчид хамрагдсан бол хоёрдугаар шат буюу бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг энэ сарын 10-13-ны өдрүүдэд 17 сумын Ерөнхий боловсролын 25 сургуулийн 500 гаруй сурагчидтай, гуравдугаар шат буюу аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг мөн энэ сарын 18-19-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Гуравдугаар шатны тэмцээнийг Сүхбаатар сумын “Партизаны талбай”, Алтанбулаг сумын “Оргидог булаг”-т зохион байгуулсан ба нийт 8 сумын Ерөнхий боловсролын 12 сургуулийн 140 гаруй сурагчид, 20 орчим багш нар оролцсон бол тэднийг бэлтгэх, чиглүүлэх, сум болон бүс, аймгийн аваргын шалгаруулалтыг зохион

байгуулах ажилд 300 гаруй албан хаагч, багш, ажилчид татагдан оролцсон юм. Тус тэмцээнд 8 сумын 12 Ерөнхий боловсролын сургуулийн 140 гаруй сурагчид хурд хүч, авхаалж самбаа, авьяас чадвар, мэдлэг оюунаа сорин өрсөлдсөнөөс тэргүүн байранд Мандал сумын 2 дугаар сургуулийн Б.Тэмүүжин захирагчтай “Сүлд” тасаг шалгарч шилжин явах цом, алтан медаль, өргөмжлөл, дурсамж, мөнгөн шагнал, Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхийн бичгээр шагнагдлаа.

Тэмцээний дэд байранд Мандал сумын 1 дүгээр сургуулийн Б.Билгүүндалай захирагчтай “Шонхор” тасаг, гутгаар байранд Мандал сумын Түнхэл тосгоны 5 дугаар сургуулийн Б.Тэмүүжин захирагчтай “Альфа” тасаг, тусгай байранд Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн Б.Баярсайхан захирагчтай “Бүргэдэй” тасгууд тус тус шалгарч өргөмжлөл, дурсамж, мөнгөн шагналаар шагнагдлаа.

Хошууч М.ГАНБАТ



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
23	6

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
36	26

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,126.00	3,130.0
EUR	3,365.0	3,378.0
CNY	470.00	472.00
RUB	52.00	52.60
JPY	24.50	24.70
KRW	2.51	2.53

ЗУРХАЙ



2022.05.26 /ПҮРЭВ ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 26

ЗУНЫ ТЭРГҮҮН ХӨХӨГЧИН МОГОЙ САРЫН НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Үс засуулбал:
Жаргал үргэлжид ирнэ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
05.02-20.36
Барилдлага:
Үл зохилдох
Шүтэн барилдлага:
Хурьцахуй
Суудал: Хий

Энэ өдөр гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба угаал үйлдэх, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Газар хагалах, ус булгийн эх малтах, багдадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод урд зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал үргэлжид ирэх сайн.



“МОНГОЛ ЦЭРЭГ-ДЭЛХИЙН ЦЭРЭГ” СЭДЭВТ НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ АМЖИЛТТАЙ БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ



Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Монгол цэрэг энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний түүхт 20 жилийн ойг угтан Баян-Өлгий аймгийн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын хамтран зохион байгуулсан “Монгол цэрэг-Дэлхийн цэрэг” сэдэвт нээлттэй хаалганы өдөрлөг энэ сарын 25-ны өдөр орон нутгийн цагаар 10.00-14.00 цагийн хооронд Баян-Өлгий аймгийн төв талбайд ёслол төгөлдөр зохион байгуулагдаж дууслаа.

Нээлттэй хаалганы хүрээнд Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн үлээвэр найрал хөгжмийн бэлтгэсэн “Жалам хар” бүжгийн цогцолбор, Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийн алба хаагчдын гардан тулааны үзүүлэх тоглолт, дэд хурандаа Н.Естайя захирагчтай Гал түймэр унтраах, аврах 31 дүгээр ангийн “Өндрөөс буух болон байлдааны тархалт”

үзүүлэх тоглолтуудын аймгийн иргэдэд толилуулсан юм. Эрдээг нь иргэдэд Иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, цэрэг эх оронч үзлийг нэмэгдүүлж чадсан юм.

Мөн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах асар, майхнууд дэлгэгдлээ. Нээлтийн арга хэмжээний төгсгөлд Монгол цэрэг энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний түүхт 20 жилийн ойг угтан олон бүтээлч ажлуудыг зохион байгуулсан бөгөөд тэр дундаа “Гар бөмбөг”-ийн тэмцээн, “Гар зураг”-ийн уралдааны шилдгүүд болсон баг тамирчид, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад өргөмжлөл, медаль, мөнгөн шагналыг хүндэт зочдоор гардуулан өглөө.

“ЦЭНХЭР ДУУЛГАТАН” УРЛАГИЙН ХЭСЭГЧИЛСЭН ТОГЛОЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ ЯВУУЛАВ

Хурандаа У.Буянжаргал захирагчтай Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн алба хаагчдын төлөөлөл Баян-Өлгий аймгийн Өлгий, Бугат сумын ард иргэд тэр дундаа Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад “Цэнхэр дуулгатан” урлагийн хэсэгчилсэн тоглолтыг зохион байгууллаа.

Мөн уг тоглолтын үеэр ахлагчийн төлөөллөөс яриа таниулгыг хийсэн бөгөөд ажиллагааны үүрэг зориулалт, үүрэг гүйцэтгэх тухайн цаг үеийн нөхцөл байдал, цэрэг дайчдын сэтгэл зүй, Монгол цэргийн дайчин уламжлал, эх оронч үзэл, хүмүүжил,

Монгол цэргийн тэсвэр хатуужил, эх орны үнэ цэнэ хаана, юунд оршдог вэ? гэх зэрэг олон асуудлыг хөндөж ярьсан нь төгсөх ангийн сурагчдад урлагаар дамжуулан гоо зүйн мэдлэг олгохоос гадна эх орноо улам хайрлах сэтгэхүйг нэмэгдүүлсэн талархал, хайр, хүндэтгэл дүүрэн тоглолтыг үзэж сонирхууллаа.

Хэсэгчилсэн тоглолтын төгсгөлд сумын засаг дарга, сургуулийн удирдлага, сурагчид талархлаа илэрхийлж байлаа.

Ахлах дэслэгч Б.ДОЛГОРСҮРЭН



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 529,537,848

Эдгэрсэн

Нийт: 499,985,474

Нас барсан

Нийт: 6,306,016

Цахим шууданд

ЗАЛУУ ХОСУУДЫН ГЭРЛЭХ ЁСЛОЛЫН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Зэвсэгт хүчний 325 дугаар анги

Энэ сарын 20-ны өдөр Завхан аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан "Тогтвортой амьдрал-Амгалан гэр бүл" арга хэмжээний хүрээнд "Олон улсын гэр бүлийн өдөр"-ийг тохиолдуулан Зэвсэгт хүчин болон Төрийн цэргийн болон хууль сахиулах

байгууллагуудад ажиллаж буй залуу гэр бүлүүдийн гэрлэлтийг зохион байгууллаа. "Хаан бугуйвч, Хатан сүйх" ёслолд Зэвсэгт хүчний 325 дугаар анги, Онцгой байдлын газар "Алтай-Улиастай эрчим хүчний систем" ТӨХК, Цагдаагийн газар зэрэг байгууллагуудын 10 залуу хосын гэрлэлтийг баталсан юм. Зэвсэгт хүчний 325

дугаар ангиас үлээвэр найрал хөгжмийн хөгжимчин дэд ахлагч О.Пүрэвсүрэн гэргийн хамт оролцсон бөгөөд тэдний гэрлэлтийн ёслолын арга хэмжээнд ангийн ахлагч, тэргүүн ахлагч Д.Батбаяр, үлээвэр найрал хөгжмийн удирдаач ахлагч Э.Эрдэнэсүх болон тус салааны бие бүрэлдэхүүн оролцож баяр хүргэж мэндчилгээ дэвшүүлээ.

МОНГОЛ ЦЭРЭГ-ДЭЛХИЙН ЦЭРЭГ СУРТАЛЧИЛГААНЫ АЖИЛ ҮРГЭЛЖИЛСЭЭР...



Зэвсэгт хүчний 331 дүгээр анги

Монгол цэрэг энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг угтан Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийн уулын тусгай батальон сурталчилгааны ажлыг олон чиглэлээр зохион байгуулан ажиллаа. Сурталчилгааны ажлын хүрээнд Сагсай сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад нээлттэй хаалганы өдөрлөгийг энэ сарын 18-ны өдөр ангийн байрлалд зохион байгуулав.

Өдөрлөгөөр сурагчдад ангийн жагсаалын талбайд зэвсэг, уулын тусгай хэрэгсэл, хээрийн гал тогооны хэрэгслийг танилцуулж, ангийн штаб, дайчин алдрын танхим үзүүлж, үлээвэр найрал хөгжмийн салаа хэсэгчилсэн тоглолт сонирхуулсан юм.

Мөн энэ үеэр ирээдүйд Зэвсэгт хүчинд алба хаах сонирхолтой Баян-Өлгий аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 16 сурагчийн мөрөөдлийг биелүүлж,

тэднийг нэг өдөр ангийн байрлалд хүлээн авлаа. Тэд ангитай танилцах явцад "Дэлхийн цэрэг-бидний мөрөөдөл" сэдэвт нэвтрүүлгийн зураг авалтыг аймгийн Саян телевизтэй хамтран зохион байгуулсан юм. Түүнчлэн сурагчидтай Зэвсэгт хүчний талаар чөлөөт ярилцлага өрнүүлж, энхийг сахиулагчдын эрхэм үүргийг сурталчлав. Өдөрлөгийн төгсгөлд сурагчид "Уулын тусгай батальоны цэрэг болсон энэ өдөр хамгийн дурсгалтай байлаа" хэмээн талархлаа илэрхийлсэн юм.

ШҮХЭРЧИН ДАЙЧИД ЕБС-ИЙН АХЛАХ АНГИЙН СУРАГЧДАД ЭНХИЙГ САХИУЛАХ ҮЙЛСИЙГ СУРТАЛЧИЛЛАА

ИХ ДЭЭД СУРГУУЛИУДЫН ТӨГСӨХ ДАМЖААНЫ ОЮУТНУУДАЙ УУЛЗАЛТ ХИЙВ



Зэвсэгт хүчний 284 дүгээр анги

Монгол Улсын Зэвсэгт хүчин энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг тохиолдуулан ангийн томилгоот сурталчилгааны бүрэлдэхүүн энэ сарын 19, 20, 23-ны өдрүүдэд Их дээд сургуулийн

сурагчидтай "Энхийг дэмжих ажиллагааны оролцоо" сэдэвт уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтын хүрээнд Монгол Улсын зэвсэгт хүчний энхийг сахиулах ажиллагааны талаар сурталчлахаас гадна "Байр зүйн албаны үүсэл, хөгжил, гүйцэтгэх

үүрэг", "Зэвсэгт хүчний үүрэг зориулалт, хуулиар хүлээсэн үүрэг", "Цэргийн жинхэнэ алба хаагч болох боломж", түүнд тавигдах шаардлагын талаар сонирхолтой ариа таниулгыг хийлээ. Тус уулзалтад 9 их дээд сургуулийн төгсөх дамжааны 364 оюутнууд хамрагдсан юм.



Зэвсэгт хүчний 084 дүгээр анги

Монгол цэрэг энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг тохиолдуулан ангийн шүхэрчин дайчид, Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабтай хамтран Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад Зэвсэгт хүчнийг сурталчлах ажиллагааг зохион

байгууллаа. Сурталчилгааны ажлын хүрээнд Баянзүрх дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн 21, 33, 48, 102 дугаар сургуулиудын 280 гаруй сурагчдад хүүхэд залуусыг цэрэг-эх оронч үзэл хүмүүжлээр төлөвшүүлэх, Ирэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, энхийг сахиулах үйлсийг сурталчлах олон

талт ажлыг зохион байгуулав. Тодруулбал, ангийн танилцуулга, видео бичлэгийг үзүүлж, ахмад Г.Баярбямба, сургагч ахлагч Т.Бат-Эрдэнэ, ахлах ахлагч Л.Батбаяр нар ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн талаар өөрсдийн туршлага сургаж, санал сэтгэгдлийг хүүхэд залуучуудад хуваалцаж, төгсөлд нь ангийн зэвсэг, шүхрийн үзэсгэлэнг танилцууллаа. Энэ үеэр Зэвсэгт хүчний шүхэрчин дайчдын онцлог болоод Энхийг дэмжих ажиллагааны талаар сонирхон асууж, зарим хүүхдүүд цэргийн алба нэр төртэйгөөр хаах болно гэдгээ итгэл төгс хуваалцсан юм. Энэхүү Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчилж байгаа үйл ажиллагаа нь олон хүүхэд залуус цэрэг дайчдыг хүндэтгэх, цаашлаад эх орноо хайрлах, эр цэргийн алба хаах хүсэл сонирхлыг төрүүлж өгснөөрөө онцлог байлаа.

Ахмад Ч.НЯМСҮРЭН

ТӨРИЙН ИХ ЦАГААН ТУГАА ЗАЛЖ СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛАА ӨРГӨН ДЭЛГЭР ТЭМДЭГЛЭЛЭЭ

Зэвсэгт хүчний 232 дугаар анги

Монгол Улс НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг угтаж олон ажил арга хэмжээг төлөвлөн шат дараатай зохион байгуулж байна.

Даян дэлхийн энх тайван, амар амгалангийн төлөө эх орныхоо өмнө хүлээсэн өндөр хариуцлагатай үүргээ нэр төртэй гүйцэтгэсэн үе үеийн цэнхэр дуулгатай, энхийг сахиулагчдаа төлөөлөн сум орон нутгийн ард иргэд, хүүхэд залуучуудад Зэвсэгт хүчин, анги байгууллагын үйл ажиллагаа, цэргийн гэрээт

албыг сурталчлан таниулж "Олон улсын энхийг дэмжих ажиллагаанд Монгол улсын оролцоо", сэдвээр яриа хийж, "Монгол цэрэг энхийн үйлсэд баримат нэвтрүүлгийг үзүүлж, Офицер ахлагч, хугацаат цэргийн алба хаагчдын бэлтгэсэн жагсаалын болон гардан тулааны үзүүлэх тоглолт "Цэнхэр дуулгатай" урлагийн хэсэгчилсэн тоглолтыг зохион байгуулав.

Мөн өдөрлөгөөр энхийг сахиулагч булан, ТЦОТ-ны зэвсэглэл, Төрийн Их цагаан тугийг залах ёслолын ажиллагаанд оролцох шарга морь, хүндэт харуулын хувцас хэрэглэл, төрийн дээд хэмжээний ёслолд оролцох

агт морь, хувцас хэрэглэл, олон улсын аравт морин цэргийн уралдааны агт морь, тоног хэрэгсэл хувцас зэргийг үзүүлэгт бэлтгэж иргэд, хүүхэд залуучуудын дурсгалын зургийг авч үнэ төлбөргүй тарааж, цэргийн хоолоор хөнгөлөлттэй үйлчиллээ.

Ахмад Ц.ОТГОНСҮРЭН

